

## ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас. 2018 оны 9 сарын дугаар.

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн Газрын 2019 оны хуанлид оруулах гэрэл зургийн уралдааныг зохион байгуулж байна. (10 дугаар сарын 14-ний ням гариг хүртэл.) Тодорхой мэдээллийг [Эндээс](#) (монголоор) авна уу.

### Тэргүүн Мэдээ.

**Гамшгийн эрсдлээс сэргийлэх сургуулийн боловсролыг дэмжих зорилгоор багш нарт зориулсан сургалт зохион байгуулав.**



9 сарын 17-ны өдөр ТХА-ны “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд гамшгийн эрсдлээс сэргийлэх сургуулийн боловсролыг дэмжих зорилгоор багш нарт зориулсан анхны сургалт зохион байгуулагдав. Монгол улсын сургуулиудад гамшгийн эрсдлээс хамгаалах боловсрол олгодоггүй нь гамшгаас хамгаалах салбарын тулгамдсан асуудлын нэг юм. Энэхүү төслөөр гамшгаас хамгаалах боловсролын үйл ажиллагааны удирдамж болох “Аюулгүй амьдралын боловсролын хөтөлбөр”-ийг боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд энэ удаагийн сургалтаар гамшгаас хамгаалах сургалтыг явуулах 60 орчим багш заах арга зүйд суралцав. 10 сард сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан сургалт явуулахаар төлөвлөж байна.

### Төслийн хэрэгжилт

**Мэдээллийн харилцааны технологи (ICT) ба багш нарын сургалтын материалыг боловсруулах төсөл**



9 сарын 13-ны өдөр Өвсний үндэс ТХА-ны “Хөдөөгийн бага боловсролын чанарыг сайжруулахад мэдээллийн харилцааны технологийг оновчтой ашиглах нь төслийн” үйл ажиллагааны нээлтийн хурал болов. Уг төслийг Токиогийн Технологийн Сургууль, МУБИС хамтран хэрэгжүүлэх бөгөөд орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан цахим сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулан, сургалтанд ашигласнаар багш нарын сургалтын аргазүйг сайжруулах зорилгоор 2023 он хүртэл хэрэгжүүлэх юм. Монгол улсад хот хөдөөгийн боловсролын ялгаа тулгамдсан асуудлын нэг болоод байгаа бөгөөд сургалтад мэдээллийн харилцааны технологийг ашиглан, орон зайн саадыг даван туулж уг асуудлыг шийдэх энэхүү төсөл нь орчин үеийн боловсролын хөгжлийн загвар болно гэж үзэж байна.

**Эх баригч болон сувилагч нарт чиглэсэн жирэмсний үеийн эрүүл мэндийн хяналт сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулагдлаа.**



9 сарын 17-20-ны өдрүүдэд Өвсний үндэс ТХА-ны “Жирэмсний хяналтын чадавхийг сайжруулах болон эх барих тусламж үйлчилгээний ур чадварыг сайжруулах төслийн” (Япон талын хэрэгжүүлэгч байгууллага: Кишокай эрүүл мэндийн корпораци) хүрээнд эх баригч, сувилагч нарт зориулсан жирэмсний үеийн эрүүл мэндийн хяналтын чадавхийг сайжруулах сургалт зохион байгуулагдсанаар төслийн үйл ажиллагаа эхэллээ. Энэхүү төсөл нь 2 жилийн хугацаанд хэрэгжих ба төсөлд хамрагдаж буй эх баригч, сувилагч нар жирэмсний үеийн хяналтын хөтөлбөрийг зохих зөв зүйтэй тогтвортой хэрэгжүүлж чадахуйц удирдах чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөтэй байна. Энэ удаагийн сургалтад Нийслэлийн Өргөө амаржих газар болон нийслэлийн 20 гаруй эх баригч, сувилагч нар хамрагдаж бүлгийн ажиллагаа зэрэгт идэвхтэй оролцлоо.

## **“Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон Олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төслийн 2-р шатны төслийн Хамтарсан удирдах хорооны 4-р хуралдаан болов.**



9 сарын 12-ны өдөр ТХА-ны “Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон Олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” төслийн 2-р шатны төслийн Хамтарсан удирдах хорооны 4-р хуралдаан болов. Уг төслийн хүрээнд ТЕГ-ын ажилтнуудын олон улсын татвар ногдуулалт ба хураалтын чадавхийг бэхжүүлэх, татварын хуулийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх юм. УИХ-ын 2018 оны намрын чуулганаар татварын багц хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг нэн тэргүүнд хэлэлцэхээр болоод байгаа бөгөөд эдгээр хуулийн төслийг боловсруулах явцад төслийн зүгээс Японы татварын системийн тухай мэдээллээр хангаж, шаардлагатай зөвлөмж өгч ирсэн юм. Энэ удаагийн Хамтарсан удирдах хорооны хуралдаан дээр Монгол талын холбогдох албан тушаалтнууд төслийн зүгээс оруулж буй хувь нэмрийг өндрөөр үнэлэн, татварын системийн шинэчлэлд чиглэсэн дэмжлэгийг үргэлжлүүлэн үзүүлнэ гэдэгт найдаж байгаагаа илэрхийлэв.

## **Нийгата мужийн олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс зохион байгуулсан Япон хэлний уран илтгэлийн тэмцээн болов.**



9 сарын 13-ны өдөр Нийгата мужийн олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс япон хэлний уран илтгэлийн тэмцээнийг Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төвд зохион байгуулж, тэмцээнд ЖАЙКА-ын Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Сато шүүгчээр оролцов. Их сургууль болон коосэний төлөөлөл 8 оюутан “Япон монголын найрамдалт хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлэх вэ?” сэдвээр илтгэл тавьж, тэргүүн байр эзэлсэн Амаржаргал (Монгол коосэн технологийн коллеж 4-р курс) Нагаока коосэний оюутантай тогтоосон харилцаагаараа жишээ татан, хүмүүс хоорондын харилцаа найрамдалт хамтын ажиллагааг бэхжүүлэхэд маш чухал үүрэгтэй болохыг илтгэлдээ дурдсан юм. Тэргүүн байр эзэлсэн 3 оюутан 2019 оны 3 сард Нийгата мужид уригдан тус мужтай танилцах аялал хийнэ.

## **Сайн дурын үйл ажиллагаа**

### **Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга.**

### **МСҮТ дахь боловсон хүчин бэлтгэх үйл ажиллагаа.**



ХНХЯ-ны бодлого чиглэлийн дагуу практик сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан Монгол улсад өндөр чадавхитай боловсон хүчин бэлтгэх зорилгоор МСҮТ зэрэг сургалтын байгууллагад сайн дурын гишүүдийг илгээн ажиллуулж байна. Одоогийн байдлаар Сэлэнгэ, Архангай, Хөвсгөл, Дундговь, Төв зэрэг аймгуудад компьютерийн сургагч багш, компьютерийн техникч, гар урлаач, тогооч, гоо сайханч гэсэн мэргэжлээр 5 сайн дурын гишүүн монгол багш нартай идэвхтэй хамтран ажиллаж байна. Цаашид ч орон нутгийн МСҮТ-д сайн дурын гишүүн илгээж, монгол багш нар болон оюутнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.



Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага.(ЖАЙКА) Монгол дахь төлөөлөгчийн газар.

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс  
(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)  
Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 Имэйл: mg\_oso\_rep@jica.go.jp